



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ

**МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН  
ЕРӨНХИЙ ГАЗАР**

15170 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Барилгачдын талбай 13, Засгийн газрын XII байр,  
Утас: 26-47-86, Факс: (976-51) 26-60-88  
E-mail: info@inspection.gov.mn, http://www.inspection.gov.mn

2019.05.23 № 02/1806  
танай 2019.05.08 -ны № ХЭГ/1313 -Т

Мэдээлэл хүргүүлэх тухай

Манай газарт хаягдал аккумулятор дахин боловсруулах чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдэд хяналт шалгалт хийх тухай хүсэлтийг 2019 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн ХЭГ/1313 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын баталсан 01/162 тоот удирдамжийн дагуу Баянзүрх дүүргийн 11 дүгээр хороонд байрлах аккумулятор дахин боловсруулах “Заламт гол” ХХК, “Хос даль” ХХК, Налайх дүүргийн 4-р хороонд байрлах “Болор Аграмба” ХХК-ийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтын танилцуулга, дүгнэлтийг хүргүүлж байна. Хүлээн авч танилцана уу.

Хувийг: Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Цагдаагийн ерөнхий газар, Аюултай хог хаягдлын үндэсний холбоонд

ДЭД ДАРГА  Д.ЭНХСАЙХАН





МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ  
МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ЕРӨНХИЙ ГАЗАР  
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТАНИЛЦУУЛГА

2019 оны 05 дугаар  
сарын 16 ны өдөр

Дугаар 01/21

Улаанбаатар


Аюултай хог хаягдал дахин боловсруулах  
үйлдвэрүүдэд төлөвлөгөөт бус хяналт  
шалгалт хийсэн тухай

### НЭГ. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ЗОРИЛГО


Монгол Улсын Ерөнхий сайдаас өгсөн үүрэг даалгаврын дагуу Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас Баянзүрх дүүргийн 11 дүгээр хороонд байрлах аккумулятор дахин боловсруулах "Заламт гол" ХХК, "Хос Даль" ХХК, Налайх дүүргийн 4 дүгээр хороонд байрлах "Болор Аграмба" ХХК-ийн үйл ажиллагаанд "Байгаль орчныг хамгаалах тухай", "Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай", "Усны тухай", "Газрын тухай", Кадастрын зураглал ба газрын тухай, Хаягжилтын тухай, "Химийн хорт болон аюултай бодисын тухай", "Хог хаягдлын тухай", "Эрүүл ахуйн тухай" хууль, "Хөдөлмөрийн тухай", "Хөдөлмөрийн аюулгүй байдал", "Цөмийн энергийн тухай" болон тэдгээрт нийцүүлэн гаргасан норм дүрэм, стандартын хэрэгжилтийг шалгаж, илэрсэн зөрчил дутагдлуудыг арилгуулах, үйлдвэрийн үйл ажиллагаанаас хүрээлэн буй орчин бохирдуулсан эсэхийг тогтоох, цаашид авах арга хэмжээний саналыг боловсруулахад хяналт шалгалтын зорилго оршлоо.

### ХОЁР. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН БҮРЭЛДЭХҮҮН, ХУГАЦАА

Хяналт шалгалтыг Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын Байгаль орчны хэлтсийн дарга, улсын ахлах байцаагч Д.Цэрэндаш ахалж, Байгаль орчны хяналтын улсын ахлах байцаагч У.Өлзийцэцэг, С.Нямжав, Байгаль орчин, газар, геодези зураг зүйн хяналтын улсын ахлах байцаагч Г.Нарантуяа, Эрүүл мэнд, боловсрол, соёлын хяналтын газрын орчны эрүүл ахуйн хяналтын улсын ахлах байцаагч Б.Баясгалан, Хөдөлмөр, нийгмийн хамгаалал, тусгай хяналтын газрын хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын ахлах байцаагч З.Мөнхтуул, хөдөлмөрийн хяналтын улсын ахлах байцаагч С.Баяраа, Цөмийн болон цацрагийн аюулгүй байдлын хяналтын газрын цацрагийн хяналтын улсын байцаагч Б.Бямбацогт, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн удирдлагын газрын ахлах мэргэжилтэн Д.Тэмүүлэн /тохиролцсоноор/, мэргэжилтэн А.Оюун /тохиролцсоноор/, Цагдаагийн ерөнхий газрын Мөрдөн байцаах газрын байгаль орчны эсрэг гэмт хэрэг



шалгах хэлтсийн ахлах мөрдөгч цагдаагийн хошууч Ш.Хуягбаатар /тохиролцсоноор/, Нийслэлийн хот байгуулалт, хөгжлийн газрын ахлах мэргэжилтэн А.Баттөмөр /тохиролцсоноор/, Баянзүрх дүүргийн Газар, зохион байгуулалтын албаны дарга Д.Бат-Ундрах /тохиролцсоноор/, Монголын байгаль орчны иргэний зөвлөлд ТББ-ийн удирдах зөвлөлийн гишүүн Н.Эрдэнэсайхан /тохиролцсоноор/ нарын бүрэлдэхүүнтэй хамтран 2019 оны 04 дүгээр сарын 29-ний өдрөөс 2019 оны 05 дугаар сарын 10-ны өдрүүдэд хяналт шалгалтыг хийж гүйцэтгэлээ.



## **ГУРАВ. ШАЛГАЛТЫН ЯВЦАД ХИЙГДСЭН АЖИЛ, ХАМРАГДСАН АСУУДЛУУД**

### ***Байгаль орчин, газар, геодези зураг зүйн хяналтын чиглэлээр:***

Заламт гол" ХХК, "Хос Даль" ХХК, "Эйч Би Жи Си" ХХК /хуучнаар "Болор Аграмба" ХХК/-ийн аккумулятор дахин боловсруулах үйлдвэрийн байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт, үйл ажиллагаанаас үүсч байгаа хүхрийн хүчлийн уусмал, хүхрийн хүчлийн бохирдолтой хуванцар хаягдлын устгал болон ахуйн хог хаягдлын менежмент, ус ашиглалтын байдалд хяналт шалгалтыг хийж гүйцэтгэлээ.

Аж ахуйн нэгж байгууллагуудын газар ашиглалтын байдалд 2.12 кодтой Газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагч иргэн болон аж ахуйн нэгж, байгууллагыг шалгах хяналтын хуудсаар эрсдэлийг үнэлж, УИХ-ын 2013 оны 02 дугаар сарын 08-ны 23 дугаар тогтоолоор батлагдсан "Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлагын баримт бичиг", Хонхор хаяа хотын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд аюултай хог хаягдал дахин боловсруулах үйлдвэрүүдийн байрлаж байгаа газрын төлөвлөлт, Нийслэлийн Газрын кадастрын мэдээллийн сан, Баянзүрх, Налайх дүүргийн Газрын албанаас газар эзэмших эрхийн захирамжийн хуулбар, баримт бичгүүд гаргуулав.

### ***Орчны эрүүл ахуйн хяналтын чиглэлээр:***

Үйлдвэрийн үйл ажиллагаанаас хүрээлэн буй орчин бохирдож буй эсэхийг тодорхойлохоор үнс, хөрс, нуурийн уснаас 8 төрлийн дээж авч итгэмжлэгдсэн лабораторид хүнд металл, химийн шинжилгээ хийлгэхээр хүргүүлэн, үр дүнг холбогдох стандарттай харьцуулан үнэлэлт дүгнэлт өгөв.

### ***Хөдөлмөр, хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын чиглэлээр:***

Үйлдвэрүүд нь үйл ажиллагаа явуулаагүй байсан тул ажлын байранд үзлэг хийх, холбогдох баримт бичгийг хянах аргаар хийж гүйцэтгэлээ. Хөдөлмөрийн гэрээ, компанийн хөдөлмөрийн харилцаатай холбоотой эрх зүйн баримт болох компанийн хөдөлмөрийн дотоод журам, дотоодын хяналт шалгалт зохион байгуулах журам,

ажилтнуудад олгох нормын ажлын хувцасны жагсаалт баталсан захирлын тушаал, ажилчдын цалин бодсон баримтуудад үзлэг шалгалт хийсэн.

**Цацрагийн хяналтын чиглэлээр:**

Заламт гол ХХК, "Эйч Би Жи Си" ХХК /хуучнаар "Болор Аграмба" ХХК/-ийн үйлдвэрийн орчимд, үйлдвэрийн хашааны дотор болон гадна талд нийт 10 цэгт цацрагийн түвшний хяналт шинжилгээг хэмжилт хийж, тэдгээр нь хүний эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлж байгаа эсэхэд үнэлэлт дүгнэлт хийсэн.


**ДӨРӨВ.ШАЛГАЛТАД ХАМРАГДСАН ОБЪЕКТЫН ТАЛААРХ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ**  
**"Заламт гол" ХХК**

"Заламт гол" ХХК нь улсын бүртгэлийн 9011192008 тоот гэрчилгээтэй, хаягдал түүхий эд болох ашигласан аккумулятораас хар тугалга, хүхрийн хүчил, полиэтилен савыг тус тусад нь ялган, хар тугалга хайлах үйлдвэрийн байрыг барьж 2013 оноос үйл ажиллагаа явуулж эхэлсэн байна. Үйлдвэрийн байр нь төмөр карказ бүхий сэндвичин барилга, хаягдал түүхий эд хүлээн авах, хүчил ялган юүлэх, хар тугалга бүхий ялтасыг ялгах, хар тугалга хайлах, хэвэнд цутгах хэсэг, нүүрс бутлах, нүүрс оруулах тоног төхөөрөмжийг байрлуулсан нийт 720 м2 талбайтай байна. Нийт 10 ажилтантай, ерөнхий технологич, нягтлан бодогч, техникч, туслах ажилтан-2, гулдмай хураагч-2, манаач, тогооч нар улирлын чанартай, 6-10 дугаар сарын хооронд ажилладаг бөгөөд хяналт шалгалтын үед үйл ажиллагаа эхлээгүй байна.

Тугалга хайлуулах зуух нь нүүрсээр ажиллах ба 1200-1300 орчим хэмийн халуунд тугалгыг хайлж, цэвэршүүлээд хэвэнд цутгаж, 45 кг хар тугалган гулдмай үйлдвэрлэдэг байна. Жилд 75600 ширхэг, хоногт 360 ширхэг гулдмай үйлдвэрлэх хүчин чадалтай. Аккумуляторыг дахин боловсруулах үйл ажиллагаанаас 28-35%-ийн хүхрийн хүчлийн уусмалыг ялган авч Орхон аймагт үйл ажиллагаа явуулдаг Эрдмин ХХК-д Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас химийн бодис худалдах №0001116 дугаартай зөвшөөрлийн үндсэн дээр 610 тонныг нийлүүлсэн байна. Аккумуляторын гадна талын хүхрийн хүчлээр бохирдсон хуванцарыг зориулалтын бус агуулахад хадгалж байна.

Байгаль орчны хамгаалах чиглэлээр 5 жилийн хугацаанд буюу 2014-2018 онд нийт 64,0 сая төгрөг, үүнээс орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт нийт 16,15 сая төгрөг тус тус төсөвлөсөн байна. Харин 2019 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг БОАЖЯ батлуулсан ба тус төлөвлөгөөнд байгаль орчныг хамгаалах чиглэлээр 9 ажлыг тусгаж 9,9 сая төгрөг төсөвлөсөн байна.

2018 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг Нийслэлийн БОГ-ын даргын 2016.12.07-ны өдрийн А/95 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан



ажлын хэсэг хүлээж авч, 85.5% тай дүгнэгдсэн ба 2019 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг БОАЖЯ-аар батлуулсан байна.

Ус ашиглах гэрээг Дэд бүтэц, хот төлөвлөлт хариуцсан төслийн удирдагч засаг даргын орлогч Т.Батцогттой 2018.11.17-2019.11.17-ны өдрийг хүртэл хийж байгуулсан бөгөөд 07 дугаартай ус ашиглах эрхийн бичиг авсан байна. Мөн гүний усны худагт METRON загварын 3,5 м<sup>3</sup> хэмжих хязгаартай 0801486 дугаартай усны тоолуур тавиулж Стандартчилал, хэмжил зүйн газрын 024 лацаар битүүмжилж, баталгаажуулсан байна.

Баянзүрх дүүргийн Засаг даргын 2012 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн А/149 дугаар захирамжаар Ичинноров овогтой Батчимэгт БЗД-ийн 11 дүгээр хорооны нутаг дэвсгэрт Хонхорт байрлуулан аж ахуйн үйлдвэрлэлийн зориулалттайгаар 20000 м<sup>2</sup> газар 5 жилийн хугацаатай эзэмшүүлсэн байна.

Баянзүрх дүүргийн Газрын албанаас гэр бүлийн хамтын хэрэгцээний зориулалтаар газар эзэмших эрхийн гэрчилгээг 2012 оны 10 дугаар сарын 08-ны өдөр олгож, иргэн, хуулийн этгээдэд 7800 м<sup>2</sup> газар эзэмшүүлэх гэрээг 2012 оны 10 дугаар сарын 05-ны өдөр байгуулсан байна. Иргэн И.Батчимэгийн эзэмших 7800 м<sup>2</sup> газар нь нийслэлийн газрын кадастрын мэдээллийн санд нэгж талбарын 18664293578193 дугаарт улсын бүртгэлд бүртгэгдсэн байна.

Баянзүрх дүүргийн Засаг даргын 2018 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн А/467 дугаар захирамжаар иргэн И.Батчимэгийн эзэмшиж байгаа газрын эрхийн гэрчилгээг Заламт гол ХХК-д шилжүүлэн захирамжилсан байна. Дүүргийн Газрын албанаас аж ахуйн нэгж, байгууллагын газар эзэмших эрхийн 000001803 гэрчилгээг 2019 оны 02 дугаар сарын 20-ны өдөр бичиж, газар эзэмших гэрээг 2018 оны 05 сарын 08-ны өдөр байгуулсан байна.

2017 онд батлагдсан "Хог хаягдлын тухай" хуулийн шинэчилсэн найруулга, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн 116 тоот тогтоолоор баталсан Аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүртгэх, тайлагнах журам, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны А/18 тоот тушаалаар Аюултай хог хаягдлыг тээвэрлэх, цуглуулах, хадгалах, дахин боловсруулах, устгах, экспортлох үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагад зөвшөөрөл олгох журам тус тус батлагдсан учраас 2018 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 06а/7634 тоот албан бичгээр аюултай хог хаягдал дахин боловсруулах тусгай зөвшөөрлийг хүсэх тухай албан бичгийн Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд хүргүүлсэн байна. Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас холбогдох бичиг баримт бүрдээгүй учраас материалыг буцааж өгч тусгай зөвшөөрөл гаргах боломжгүй хариуг өгсөн байна.

### **“Эйч Би Жи Си” ХХК /хуучнаар “Болор Аграмба” ХХК/**

Налайх дүүргийн 4 дүгээр хороонд байрлах Болор Аграмба ХХК-ийн үйлдвэрийн үйл ажиллагаа зогссон. Үйлдвэрийн тоног төхөөрөмж, газрыг Эйч Би Жи Си ХХК худалдан авч өөрийн нэр дээр шилжүүлсэн байна.

Налайх дүүргийн Засаг даргын 2012 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн 463 дугаар захирамжаар Болор аграмба ХХК-д 17943 м<sup>2</sup> тус дүүргийн 4 дүгээр хорооны нутаг дэвсгэрт үйлдвэрийн бүсэд үйлдвэрлэлийн зориулалтаар 15 жилийн хугацаатай газар эзэмшүүлэхээр шийдвэрлэж, аж ахуйн нэгж байгууллагын 0294016 дугаар гэрчилгээ бичсэн, нийслэлийн газрын кадастрын мэдээллийн санд нэгж талбарын 18673295076727 дугаарт бүртгэгдсэн байна.

Налайх дүүргийн Засаг даргын 2019 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн А/27 дугаар захирамжаар Болор Аграмба ХХК-д 10405.0 га газрыг 15 жилийн хугацаатай үйлдвэрийн барилга, байгууламж, бусад газар зориулалтаар эзэмшүүлэхээр шийдвэрлэж аж ахуйн нэгж, байгууллагын газар эзэмших эрхийн 000001800 дугаар гэрчилгээг бичиж, газрын кадастрын мэдээллийн санд 1260510018 дугаарт бүртгэгдсэн байна.


Налайх дүүргийн Засаг даргын 2019 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн А/27 дугаар захирамжаар Эйч Би Жи Си ХХК-д үйлдвэрлэлийн зориулалтаар 15 жилийн хугацаатай газар эзэмших эрхийн гэрчилгээг шилжүүлэн шийдвэрлэж, аж ахуйн нэгж, байгууллагын газар эзэмших эрхийн 000001706 дугаар гэрчилгээ олгосон байна. Нийслэлийн Газрын кадастрын мэдээллийн санд 1260510017 дугаарт бүртгэгдсэн байна.

Эйч Би Жи Си ХХК нь Болор аграмба ХХК-аас худалдан авсан 2 үл хөдлөх барилгад ямар нэг үйл ажиллагаа явуулаагүй, шинээр эзэмшиж байгаа газарт барилгын ажил эхлүүлсэн байна.

### **“Хос даль” ХХК**

Баянзүрх дүүргийн 11 дүгээр хороонд үйл ажиллагаа явуулж байсан тус үйлдвэр нь 2018 оны 3 дугаар сард төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийхэд Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээгүй, холбогдох зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулж, аккумуляториос ялгаж авсан хүхрийн хүчлийг хууль бусаар хадгалсан тул эрүүгийн хэрэг үүсгэх тухай 2018 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн 02-01/2197 тоот албан бичгийг Нийслэлийн Цагдаагийн газарт хүргүүлсэн. Цагдаагийн Ерөнхий газрын Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг мөрдөн шалгах хэлтэст эрүүгийн хэрэг үүсэн шалгагдаж байна.

Баянзүрх дүүргийн Засаг дарын 2007 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 368 дугаар захирамжаар иргэн Эрхбат овогтой Тунгалагт 20000 м<sup>2</sup> га газар 5 жилийн



хугацаатай ногооны газрын зориулалтаар эзэмшүүлэхээр шийдвэрлэж газар эзэмших эрхий 0148675 дугаар эрхийн гэрчилгээ олгож, иргэн, хуулийн этгээдэд газар эзэмшүүлэх гэрээ байгуулан 2007 оны 12 дугаар сарын 27-ны өдөр улсын бүртгэлийн 3028/0116 дугаарт бүртгэсэн байна.

Баянзүрх дүүргийн 2012 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн А/390 дугаар захирамжаар иргэн Эрхбат овогтой Тунгалагт 20000 м<sup>2</sup> га газар 5 жилийн хугацаатай ногооны газрын зориулалтаар газар эзэмшүүлэхээр шийдвэрлэж, 2013 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн иргэн, хуулийн этгээдэд газар эзэмшүүлэх гэрээг байгуулан улсын бүртгэлийн 133028/0116 дугаарт бүртгэсэн, нийслэлийн газрын кадастрын мэдээллийн санд нэгж талбарын 18665292420355 дугаарт бүртгэгдсэн байна. Иргэн Э.Тунгалаг ногооны газрын зориулалтыг өөрчилсөн, Хос даль ХХК-д зориулалт бусаар эзэмшүүлэхээр гэрээ байгуулсан байна.

**Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлагын баримт бичгийн талаар:**

Монгол Улсын Улсын Их хурлын 2013 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 23 дугаар тогтоолоор Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлагын баримт бичгийг баталсан байна.


Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний зургийн Байгаль орчин, хог хаягдлын менежмент /1.1.8.3/ зурагт хяналтай тусгай болон аюултай хог хаягдлыг хотын дотор хүлээн авах цогцолборыг одоогийн цэвэрлэх байгууламжийн орчинд төлөвлөгдөж буй терминальд байгуулан тэндээс вагонаар, зориулалтын тээврийн хэрэгслээр зөөвөрлөн "Онцгой хаягдлын бүс"-д хүргэхээр тусгагдсан байна.

"Онцгой хаягдлын бүс"-ийг Улаанбаатар хотоос 74 км-т Улаанбаатар Багахангай чиглэлийн төмөр замын "Чулуут" өртөөнөөс баруун тийш 3.0 км-т орших хуучин оросын цэргийн ангийн зориулалттай байгууламжийг ашиглан байгуулахаар төлөвлөлтөд заасан байна.

#### **ХИМИ, ЦАЦРАГИЙН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН:**

Заламт гол ХХК, "Эйч Би Жи Си" ХХК /хуучнаар "Болор Аграмба" ХХК/-ийн үйлдвэрийн орчимд, үйлдвэрийн хашааны дотор болон гадна талд нийт 10 цэгт цацрагийн хэмжилт хийсэн. Хэмжилтийн дүнгээр хэмжилт хийсэн цэгүүдэд гамма цацрагийн тунгийн чадал 0.07-0.18 мкЗв/цаг, гадаргуудын бохирдол 8-15 бөөм/минут\*см<sup>2</sup> байна. Хэмжилтийн дүнгээс үзэхэд гамма цацрагийн тунгийн чадал нь байгалийн цацрагийн дэвсгэр түвшин (0.20 мкЗв/цаг)-ээс хэтрээгүй, бета цацрагийн хэмжээ нь Цацрагийн аюулгүйн нормын 7 дугаар бүлгийн 7.1 дэх хэсэгт заасан гадаргуугын бохирдлын байж болох хэмжээ (100 бөөм/мин\*см<sup>2</sup>)-нээс бага байна

“Заламт гол” ХХК, “Эйч Би Жи Си” ХХК /хуучнаар “Болор Аграмба” ХХК/-ийн аккумулятор дахин боловсруулах үйлдвэрийн ойролцоох орчны хөрснөөс 8 дээж авч, хар тугалга, хром, зэс, цайр, хүнцэл, кадми, сульфат гэсэн химийн үзүүлэлтээр итгэмжлэгдсэн “SGS IMME Mongolia” ХХК-ийн лаборатори, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны харъяа Байгаль орчны төв лабораторит шинжилгээнд тус тус хүргүүлж ажилласан.



### Химийн шинжилгээний дүн

Дээж авсан байрлал	LATITUDE in degrees	LONGITUDE In degrees	Хар тугалга	Хром	Зэс	Цайр	Хүнцэл	Кадми	Сульфат
<b>“Заламт гол” ХХК</b>									
Үйлдвэрийн барилгын урд хэсэг	47.745823	107.193443	>10000	45	41	146	27	5	13094
Хашааны хаалганы ойролцоо	47.751968	107.195457	>10000	141	30	96	43	10	8427
Хашааны гадна сувгийн ойролцоо	47.75198	107.195457	9219	38	39.7	130	35	7	6417
Хашаанаас баруун хойно 100 м орчим	47.753124	107.195457	452	33	22.2	71	23	<1	210
<b>“Болор аграмба” ХХК</b>									
Зуухны ойролцоох хөрс	47.772724	107.31028	>10000	20	24.8	61	38	39	74545
Хаашааны зүүн урд 30 м орчим	47.772625	107.31041	2651	156	29	64	22	1	22105
Хашааны зүүн урд 100 м орчим	47.7724	107.311234	1939	30	30.9	80	20	2	125.8
Хашааны хаалганаас 30 м орчим	47.772705	107.309372	5738	26	19.5	83	18	<1	62.2

### Хөрсний хар тугалганы шинжилгээний үр дүн





10000  
 10000  
 9219  
 452  
 10000  
 2651  
 1939  
 5738  
 ХТ04466


“Заламт гол” ХХК-ийн аккумулятор дахин боловсруулах үйлдвэрийн ойролцоох орчны хөрснөөс авсан 4 дээжинд “Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ” MNS 5850:2008 стандартад заасан зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс 4.5-100 дахин их, “Эйч Би Жи Си” ХХК /хуучнаар “Болор Аграмба” ХХК/-ийн аккумулятор дахин боловсруулах үйлдвэрийн ойролцоох орчны хөрснөөс авсан 4 дээжинд “Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ” MNS 5850:2008 стандартад заасан зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс 19.4-100 дахин их гарсан байна.

**Хөрсний хүнцэлийн шинжилгээний үр дүн**




“Заламт гол” ХХК-ийн аккумулятор дахин боловсруулах үйлдвэрийн ойролцоох орчны хөрснөөс авсан 4 дээжинд хүнцэлийн агууламж стандартад заасан зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс 3.8-7.2 дахин их, “Эйч Би Жи Си” ХХК /хуучнаар “Болор Аграмба” ХХК/-ийн аккумулятор дахин боловсруулах үйлдвэрийн ойролцоох

орчны хөрснөөс авсан 4 дээжинд хүнцэлийн агууламж стандартад заасан зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс 3-6.3 дахин их гарсан байна.




### Хөрсний кадмийн шинжилгээний үр дүн



“Заламт гол” ХХК-ний аккумулятор дахин боловсруулах үйлдвэрийн ойролцоо, хашааны хаалганы ойролцоо, хашааны гадна талын сувгийн ойролцоо авсан хөрсөнд стандартад заасан зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс кадми 0.6-3.3 дахин их, “Эйч Би Жи Си” ХХК /хуучнаар “Болор Аграмба” ХХК/-ийн аккумулятор дахин боловсруулах үйлдвэрийн зуухны ойролцоох хөрсөнд стандартад заасан зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс кадми 13 дахин их гарсан байна.


### Хөрсний сульфатын шинжилгээний үр дүн



“Заламт гол” ХХК-ний аккумулятор дахин боловсруулах үйлдвэрийн ойролцоох орчны хөрснөөс авсан 4 дээжинд сульфат нь стандартад заасан зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс 0.3-81.8 дахин их, “Эйч Би Жи Си” ХХК /хуучнаар “Болор Аграмба” ХХК/-ийн аккумулятор дахин боловсруулах үйлдвэрийн зуухны ойролцоох хөрс, зуухнаас

зүүн урд 30 метр орчим газрын хөрснөөс авсан дээжинд сульфат нь стандартад заасан зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс 138-466 дахин их гарсан байна.

“Заламт гол” ХХК-ний аккумулятор дахин боловсруулах үйлдвэрээс 338 метрт байрлах нуурын уснаас дээж авч химийн нийт 57 үзүүлэлтээр “SGS IMME Mongolia” ХХК-ний лабораторид шинжлүүлэхэд төмрийн агууламж Гадаргын усны цэврийн зэргийн ангиллын нормоор их бохирдолттой ангилалд хамрагдаж байна.



#### **ТАВ. ӨМНӨХ ХЯНАЛТ ШАЛГАЛТААР**


##### **Заламт гол ХХК:**

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг холбогдох байгууллагаар батлуулаагүй үйл ажиллагаа явуулж байсан, байгаль орчны менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөргүй, ус ашиглах дүгнэлт гаргуулаагүй, үйл ажиллагаанаас ажилчдын эрүүл мэндийн нөлөөллийг үнэлж бууруулах тухай арга хэмжээ авч ажиллагаагүй зэрэг зөрчлүүд илэрсэн тул 2013 оны 08 дугаар сарын 02-ны өдрийн 02-04-123/272 тоот, 2015 оны 07 дугаар сарын 24-ний өдрийн 06/039/56 тоот улсын /ахлах/ байцаагчийн актаар үйл ажиллагааг түр зогсоож, актаар тогтоосон шаардлагыг биелүүлсэн тул 2014 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 02-04-122/471 тоот, 2015 оны 10 сарын 27-ны өдрийн 05/079/93 тоот улсын /ахлах/ байцаагчийн актаар тус тус үйл ажиллагааг сэргээж байсан байна.

“Заламт гол” ХХК-ийн аккумуляторын хаягдал хар тугалга дахин боловсруулах үйлдвэрийн ойр орчимд байрлах ус, хөрс, агаарт хүнд металлын бохирдол байгаа эсэхийг тодорхойлохоор 2013, 2014, 2015 онуудад дээж авч шинжилгээ хийж 2013 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн 28-03-205/715 тоот, 2013 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 02-10-123/972 тоот, 2014 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн 28-03-205/397 тоот, 28-03-205/395 тоот, 2015 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 28-03-205/265 тоот, 2015 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн 02-03-060/1237 тоот орчны бохирдол зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтрээгүй улсын /ахлах/ байцаагчийн дүгнэлтүүдийг тус тус гаргасан байна.

Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас 2015 онд хийсэн төлөвлөгөөт бус хяналт шалгалтын хүрээнд “Заламт гол” ХХК-ийн үйлдвэрийн ажилтнуудын цусан дахь хар тугалгын агууламж тодорхойлох шинжилгээг АШУҮИС-ийн Хөдөлмөр, орчны эрүүл ахуйн лабораторит шинжлүүлэхэд 27.3-50.1 мкг/дл байгаа нь “Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Ажлын байрны агаар дахь хар тугалгын агууламж, ажлын байранд тавигдах шаардлага” MNS 5803:2007 стандартын 6.2-т заасан хэмжээнээс 1 ажилтны цусанд 10.1 мкг/дл-аар их байгаа нь үйлдвэрийн ажилчид хар тугалгын бохирдолд байнга өртөж, мэргэжлийн хордлого үүсч болзошгүй нөхцөлд ажиллаж байгааг тогтоосон байна. Заламт гол ХХК-ийн хаягдал аккумуляторын үйлдвэрт НМХГ-

ын улсын байцаагчдын гаргасан 2013 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн 28-03-205/584 тоот ажил үйлчилгээний тухай дүгнэлтийг хүчингүй болгох шийдвэрийг гаргуулсан. Мөн УМЭАЦТЛ-ийн 007107, 007110 тоот сорилтын дүнгээр хар тугалгын хэмжээ үхрийн хөөвөрт 19,91-89,7ppm, өвсөнд 40ppm байгаа нь САЗ/БО/19, САЗ/БО/18-ын зөвшөөрөгдөх хэмжээнээс 4-15 дахин их хэмжээгээр илэрсэн нь мал, амьтны эрүүл мэндэд эрсдэл үүсгэх нөхцлийг бүрдүүлж байсан. Иймд үйлдвэрийн үйл ажиллагааг 2015 оны 07 дугаар сарын 24-ний өдрийн 06/039/56 тоот улсын /ахлах/ байцаагчийн актаар түр зогсоох арга хэмжээ авч ажилласан.



Байгаль орчин, аялал жуулчлалын яамны сайдын 2017 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн А/124 дугаар тушаалаар байгуулсан ажлын хэсэг хяналт шалгалт хийж, ойр орчмын хөрс, уснаас дээж авч шинжилгээнд хүргүүлсэн. Шинжилгээний үр дүнгээр үйлдвэрийн орчмын хөрсөнд хартугалга 3-9 дахин их илэрсэн нь байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эрсдэлтэй байгаа нөхцөл үүссэн байгааг Сайдын зөвлөлийн хуралд танилцуулсан.

Эрүүл мэндийн яамнаас 2017 онд Баянзүрх дүүргийн 11 дүгээр хороонд оршин суугч Иргэн Д.Батцэнгэл "Заламт гол" ХХК-ийн хаягдал аккумулятор дахин боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагаатай холбоотой гомдол ирүүлснийг судалж үзээд ЭМЯ-ны Хор судлалын мэргэжлийн салбар зөвлөлөөс Иргэн Д.Батцэнгэлийн 2 хүүхдийн цусанд хар тугалганы хэмжээ ДЭМБ-ын зөвлөмж хэмжээнээс өндөр, хордлогын хөнгөн хэлбэрт байна гэсэн дүгнэлтийг гаргасан байна. Ийм учраас Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэн нь Заламт гол ХХК-ийн үйл ажиллагаанаас хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийн нарийвчилсан судалгааг хийх чиглэлийг ЭМЯ-наас хүргүүлсэн байна. Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэнгээс 2017 оны 1 дүгээр сард Хонхор тосгонд оршин суугаа 21 өрхийн 36 хүнийг хамруулан цусанд хартугалганы агууламжийг тодорхойлох шинжилгээг хийлгэхэд хор аюулын коэффициент 0.2-оос бага байгаа тул хаягдал аккумулятор боловсруулах үйлдвэрийн орчин дах хартугалганы нөлөөлөл тухайн орчинд амьдарч байгаа хүн амын эрүүл мэндэд эрсдэлгүй түвшинд байна гэсэн дүгнэлтийг гаргасан байна.

2016 онд "Заламт гол" ХХК нь хуучин аккумуляторын шингэн хүхрийн хүчлээр орчны хөрс, ус бохирдуулсны улмаас тус хорооны 3 хүүхэд хордсон мэдээлэлд ЦЕГ-ын Мөрдөн байцаах газрын Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг мөрдөх хэлтсийн мөрдөн байцаагч, цагдаагийн ахлах дэслэгч Б.Мижидсамдан эрүүгийн хэрэг үүсгэн шалгаад Нийслэлийн Баянзүрх дүүргийн прокурорын 2017 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 206 дугаар тогтоолоор Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 208 дугаар зүйлийн 208.1.1, 24 дүгээр зүйлийн 24.1.1 дэх хэсэгт заасан үндэслэлээр хэрэгсэхгүй болгосон байна.

Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын даргын 2018 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 02-01/51 тоот удирдамжийн дагуу Заламт гол ХХК-д төлөвлөгөөт хяналт шалгалт хийхэд дунд эрсдэлтэй үнэлэгдсэн байна.

**“Эйч Би Жи Си” ХХК /хуучнаар “Болор Аграмба” ХХК/**

Налайх дүүргийн 4 дүгээр хороонд байрлах тус үйлдвэр нь Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээгүй, холбогдох зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулж байсан зөрчилд улсын байцаагчийн 02-04-334/258 тоот акт үйлдэж үйл ажиллагааг нь зогсоосон. 2018 онд актыг зөрчин үйл ажиллагаа явуулж байсан тул Зөрчлийн тухай хуулийн 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу 500,000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч, эрх бүхий албан тушаалтны албан даалгавраар үйл ажиллагааг дахин зогсоох арга хэмжээг авч ажилласан.

**“Хос даль” ХХК**

Баянзүрх дүүргийн 11 дүгээр хороонд үйл ажиллагаа явуулж байсан тус үйлдвэр нь 2018 оны 3 дугаар сард төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийхэд Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээгүй, холбогдох зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулж байсан тул 1802000134 тоот зөрчлийн хэрэг үүсгэн торгуулийн арга хэмжээ авч 2018 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн прокурорын тогтоол, 04 дүгээр сарын 24-ний өдрийн 02-04-194/50 тоот улсын ахлах байцаагчийн актаар үйл ажиллагааг нь зогсоосон. Гэвч лац хөдөлгөж дахин үйл ажиллагаа явуулсан тул 2018 оны 06 дугаар сард 02-04-194/02-180445 тоот зөрчлийн хэрэг үүсгэн дахин торгуулийн арга хэмжээ авч БЗД-ийн Цагдаагийн хэлтэст улсын ахлах байцаагчийн актын биелэлтэнд хяналт тавьж ажиллах талаар 2018 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн 02-02/2168 тоот албан бичиг хүргүүлж, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг прокурорын хяналтанд хийж гүйцэтгэсэн. Тус компани нь аккумуляториос ялгаж авсан хүхрийн хүчлийг хууль бусаар хадгалсан тул эрүүгийн хэрэг үүсгүүлэхээр 2018 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн 02-01/2197 тоот албан бичгийг Нийслэлийн Цагдаагийн газарт хүргүүлсэн. Одоогоор тус компанийн хэрэг Цагдаагийн Ерөнхий газрын Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг мөрдөн шалгах хэлтэст эрүүгийн хэрэг үүсэн шалгагдаж байна.

**ЗУРГАА.ШАЛГАЛТААР ИЛРҮҮЛСЭН ЗӨРЧИЛ, ДУТАГДАЛ, ШАЛТГААН, ТҮҮНЭЭС ГАРЧ БОЛЗОШГҮЙ БУЮУ ГАРСАН ХОХИРОЛ, ЗӨРЧИГДСӨН ХУУЛЬ, ТОГТООМЖ, ДҮРЭМ, ЖУРАМ, СТАНДАРТЫН ХЭРЭГЖИЛТ;**

**Байгаль орчин, газар, геодези зураг зүйн хяналтын чиглэлээр:**

1. Заламт гол” ХХК нь аюултай хог хаягдал болох аккумуляторыг дахин боловсруулахдаа эрх бүхий байгууллагаас тусгай зөвшөөрөл аваагүй нь Хог хаягдлын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1 дэх /Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн


захиргааны төв байгууллага мэргэжлийн зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн аюултай хог хаягдал тээвэрлэх, цуглуулах, хадгалах, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаа эрхлэхэд зөвшөөрөл олгоно;/ заалтыг

2. Аюултай хог дахин боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагаанаас үүсч буй хүхрийн хүчлийн бохирдолтой хуванцар хаягдлыг эрх бүхий байгууллагад өгч устгах арга хэмжээг аваагүй нь Хог хаягдлын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх *Аюултай хог хаягдал үүсгэгч нь аюултай хог хаягдлыг эх үүсвэр дээр түр хадгалж болно;/* Аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүртгэх, тайлагнах журмын 2.3.4 дэх *Өөрийн үйл ажиллагаанаас үүсэх хог хаягдлаа устгах болон дахин боловсруулах боломжгүй тохиолдолд аюултай хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, устгах, дахин боловсруулах, экспортлох зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж, байгууллагад шилжүүлэх;/* заалтуудыг,

3. Хаягдал түүхий эд боловсруулах технологи нь маш хоцрогдсон, тугалга хайлах хэсгийг тусгаарлаагүй, хүхрийн хүчлийг ялган авах үйл ажиллагааг механикжуулаагүй, ажлын байранд ил задгай сувгаар дамжуулан хуримтлуулдаг, ажлын байрны агаарт хар тугалгын болон хүхрийн хүчлийн уур уурших нөхцөл бүрдсэн байгаа нь Химийн хорт болон аюултай бодисын тухай 13 дугаар зүйлийн 13.1 дэх *Химийн хорт болон аюултай бодис ашиглахтай холбоотой үйл ажиллагааг хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны нөхцөл, шаардлагыг бүрэн хангасан зориулалтын байр, талбайд явуулах/* заалтыг;

4. Баянзүрх дүүргийн Засаг даргын 2018 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн А/467 захирамжаар иргэн И.Батчимэгээс Заламт гол ХХК-д, Налайх дүүргийн Засаг даргын 2019 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн А/27 дугаар захирамжаар Болор аграмба ХХК-иас Эйч Би Жи Си ХХК-д шилжүүлэн захирамжилсан нь Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлагын баримт бичгийн 4.4 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1 дэх *Хот, тосгон бусад суурины газарт иргэн, аж ахуйн нэгж байгууллагад газар эзэмшүүлэх, ашиглуулах үйл ажиллагааг зөвхөн тухайн хот, тосгон, бусад суурины харьяалах засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг үндэслэн боловсрогдож батлагдсан хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, түүнд тулгуурласан үе шатны болон хэсэгчилсэн төлөвлөгөөний дагуу энэ хуульд заасан журмаар хэрэгжүүлнэ/* заалтыг;

5. Иргэн Э.Тунгалаг ногооны газрын зориулалтыг өөрчилсөн, Хос даль ХХК-д зориулалт бусаар эзэмшүүлэх эрх шилжүүлсэн нь Газрын тухай хуулийн 35 дугаар



зүйлийн 35.3.1 дэх /газар эзэмших гэрээнд заасан нөхцөл, болзлыг биелүүлэх/ заалтыг;

6. Иргэн Эрхбат овогтой Тунгалагийн эзэмшил газрын эрхийг Дүүргийн Засаг дарга 5 жилийн хугацаатай олгосон нь Газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх /Газрыг Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад 15-60 жил хүртэл хугацаатайгаар эзэмшүүлж болно. Газар эзэмших эрхийн гэрчилгээг нэг удаад сунгах хугацаа 40 жилээс илүүгүй байна/ заалтыг;

**Орчны эрүүл ахуйн хяналтын чиглэлээр:**

7. Аккумулятор дахин боловсруулах үйлдвэрийг ашиглалтад оруулахдаа газрыг нь Хөдөлмөрийн аюулгүй байдал, үйлдвэрлэлийн эрүүл ахуй. Эрүүл ахуйн хамгаалалтын бүсийн хэмжээ. Ерөнхий шаардлага" MNS 5105:2001 стандартын А.хавсралт, Эрүүл ахуйн хамгаалалтын бүс нь 1000 метрт байх стандарт шаардлагад нийцүүлэн байгуулаагүй нь Эрүүл ахуйн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3 дахь заалт, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь заалтуудыг;

8. "Заламт гол" ХХК, "Эйч Би Жи Си" ХХК /хуучнаар "Болор Аграмба" ХХК/-ийн аккумулятор дахин боловсруулах үйлдвэр эрүүл ахуйн нөхцөл, шаардлага хангахгүй байгаагаас хөрсний дээжинд хийсэн шинжилгээгээр хар тугалга, кадми, хүнцэл, сульфатын агууламж стандартад заасан зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс их гарч орчныг бохирдуулж байгаа нь "Эрүүл ахуйн тухай" хуулийн 4 дүгээр зүйлийн 4.4.2 дахь /хүн, мал, амьтанд халдвар тараах, байгаль орчинд аюултай хог хаягдлыг эрүүл ахуйн нөхцөл, шаардлагын дагуу цуглуулах, хадгалах, тээвэрлэх, тогтоосон тусгай цэгт булшлах буюу зориулалтын байгууламжид устгах;/ заалтыг;

**Хөдөлмөр, хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын чиглэлээр:**

9. Хуучин аккумулятор задалж, хүхрийн хүчил болон хар тугалгыг ялган авах, хайлуулах үед ажилчдын эрүүл мэндийн нөлөөллийг үнэлж бууруулах, гарах эрсдлээс урьдчилан сэргийлэх талаар тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлээгүй, тухайлбал үйлдвэрийн байранд чийгтэй цэвэрлэгээ тогтмол хийдэггүй, бохир агаарыг амьсгалын түвшингээс шууд татах байдлаар суурилуулаагүй, ажилчид химийн бодисын нөлөөлөлд өртөх нөхцөл бүрдсэн нь Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.1 дэх /үйлдвэрлэлийн явцад бий болсон хими, физик, биологийн хүчин зүйл нь ажлын байрны хөдөлмөрийн эрүүл ахуй, байгаль орчинд сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй байх нөхцөлийг бүрдүүлэх, техник, зохион байгуулалтын арга хэмжээ авах/ заалтыг;

10. 2017 онд ажилласан ажилчдын цусанд хар тугалга илрүүлэх шинжилгээгээр 1 ажилтны цусанд хар тугалга 50 мкг/дл илэрсэн байгаа нь "Хөдөлмөрийн аюулгүй

ажиллагаа, эрүүл ахуй. Ажлын байрны агаар дахь хар тугалгын агууламж, ажлын байранд тавигдах шаардлага" MNS 5803:2007 стандартын 6.2-т заасан / 40мкг/дл –ээс ихгүй/ хэмжээнээс их, 2018 онд ажилласан ажилтнуудад дээрх шинжилгээг хийлгээгүй байгаа нь Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх /Ажил олгогч нь эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон журмын дагуу үйлдвэрлэл, ажил, үйлчилгээтэй холбоотой, зайлшгүй шаардлагатай эрүүл мэндийн урьдчилсан ба хугацаат үзлэгт ажилтныг хамруулах/ заалтыг;


11. Хөдөлмөрийн маргаан таслах комисс захирлын тушаал гаргаагүй нь Хөдөлмөрийн тухай хуулийн 125 дугаар зүйлийн 125.1 дэх /Ажил олгогч, ажилтны хооронд гарсан хөдөлмөрийн ганцаарчилсан маргааныг хөдөлмөрийн маргаан таслах комисс, шүүх тус тусын харьяаллын дагуу шийдвэрлэнэ./, 126 дугаар зүйлийн 126.2 дах /Хөдөлмөрийн маргаан таслах комиссын дүрмийг Засгийн газар батална./ заалтуудыг;

12. Ажил олгогчийн хөдөлмөрийн гэрээг цуцалсан тушаалууд нь хуулийн зүйл заалтыг бүрэн тусгаагүй Хөдөлмөрийн тухай хуулийн 130 дугаар зүйлийн 130.1 дэх /Ажил олгогч нь ажилтны төлөөлөгчдийн саналыг харгалзан хөдөлмөрийн дотоод журмыг хууль тогтоомжид нийцүүлэн баталж мөрдүүлнэ. /заалтыг;

13. БНХАУ-аас ирж ажилсан мэргэжилтнүүдийг өөрийн компанийн нэр дээр зөвшөөрөл авч ажиллуулаагүй нь Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх /Байгууллага нь гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авахын өмнө хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, түүний эрх олгосон байгууллага /цаашид "эрх бүхий байгууллага" гэх/-ын зөвшөөрлийг урьдчилан авсан байна/ заалтыг;

14. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн эрсдэлийн үнэлгээ хийлгээгүй, осол дөхсөн тохиолдлыг судалж бүртгэхгүй байгаа нь "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай" хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.4 дэх /Ажлын байранд учирч болзошгүй аюулыг илрүүлэх, тогтоох, үнэлэх, бууруулах, арилгах зорилгоор эрсдэлийн үнэлгээ хийх./ заалтыг;

15. Үйлдвэрлэлийн аюултай хүчин зүйлийн үйлчлэл бүхий эрсдэлтэй ажлын байранд ажилчдыг хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн сургалтад хамруулаагүй нь "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай" хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх /Ажил, хөдөлмөр эрхэлж байгаа иргэн, ажилтан болон ажил олгогч нь хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан журмын дагуу хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтад хамрагдаж мэдлэг, дадлагатай болсон байна./ заалтыг;





16. Тоног төхөөрөмж аюулгүй ажиллагааны гэрчилгээ аваагүй нь Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.3 дахь /Машин механизм, тоног төхөөрөмжийг суурилуулах, их засварын дараа ашиглалтад оруулахдаа мэргэжлийн хяналтын байгууллагаар хянуулж зөвшөөрөл, гэрчилгээ авсан байх;/ заалтыг;

17. Ажлын хувцас, хамгаалах хэрэгслийг олгосон гэх боловч уг хамгаалах хэрэгсэл нь шаардлага хангаж байгаа эсэхэд дүгнэлт гаргуулаагүй байгаа нь Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх /Ажил олгогч нь ажилтныг түүний ажлын нөхцөл, ажил үүргийн онцлогт тохирсон ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслээр үнэ төлбөргүй хангах үүрэгтэй./, 18 дугаар зүйлийн 18.2.5 дахь /ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслийг зориулалтын дагуу хэрэглэх;/ заалтуудыг тус тус зөрчиж байна.

### **ДОЛОО. АВСАН АРГА ХЭМЖЭЭ, МЭРГЭЖЛИЙН ТУСЛАЛЦАА, ЗӨВЛӨГӨӨ ӨГСӨН БАЙДАЛ;**

Аюултай хог хаягдлыг цуглуулах хүлээн авах, дахин боловсруулах үйл ажиллагаа нь Улаанбаатар хотыг 2020он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлагын баримт бичигт тусгагдсан газарт байх талаар аж ахуй нэгжүүдэд тайлбарлаж өгсөн.

Заламт гол ХХК нь аюултай хог хаягдал дахин боловсруулах үйл ажиллагааг эрх бүхий байгууллагаас тусгай зөвшөөрөл аваагүй, ажлын байранд дах хөдөлмөрийн аюулгүй байдал хангагдахгүй үйлдвэрлэлийн осол, хурц хордлого гарах магадлал үүссэн байх тул үйл ажиллагааг Нийслэлийн прокурорын газрын 38 тоот прокурорын тогтоолоор түр зогсоож, илэрсэн зөрчилд 3,000,000 төгрөгийн шийтгэлийн арга хэмжээ авч, 1902000264 тоот зөрчлийн хэргийг шийдвэрлэж зөрчлийн үр дагаварыг арилгах албан даалгавар өгсөн.

### **НАЙМ. ШАЛГАЛТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ, ДУТАГДЛЫН ШАЛТГААН, БОДИТ НӨХЦӨЛ БАЙДЛЫН ТАЛААРХ ДҮГНЭЛТ;**

1. Заламт гол ХХК, Эйч Би Жи Си ХХК /хуучнаар Болор Аграмба ХХК/-ийн аккумулятор дахин боловсруулах үйлдвэрүүдийн ойролцоох орчны хөрснөөс дээж авч итгэмжлэгдсэн лабораторит шинжлүүлсэн хүнд металлын химийн шинжилгээний дүнг "Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ" MNS5850:2008 стандартад харьцуулахад зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хар тугалгын агууламж 4.5-100 дахин их, хүнцэлийн агууламж 3-6.3 дахин их, кадмийн агууламж 0,6-13 дахин их, сульфатын агууламж 0.3-466 дахин их гарсан гарч байгаа нь үйлдвэрийн үйл ажиллагаанаас хүрээлэн буй орчинд хүхрийн хүчил болон хүнд

металлын бохирдол үүсч тухайн бүс нутагт амьдарч байгаа иргэд болон ажилчдын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх нөхцөл байна.

2. Хаягдал аккумулятороос хүхрийн хүчил ялгах, хартугалга хайлуулах үйлдвэрийн 1000 метрт байх эрүүл ахуйн хамгаалалтын бүсийг тогтоогоогүй, Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлагын баримт бичигт тусгагдаагүй аюултай хог хаягдлын байршлийн шаардлага хангахгүй газарт үйл ажиллагаа явуулж байгаа Заламт гол<sup>1466</sup> ХХК, Эйч Би Жи Си ХХК /хуучнаар Болор Аграмба ХХК/, Хос даль ХХК-ийн үйлдвэрүүдийг хүн ам суурьшиж байгаа бүсээс нүүлгэн шилжүүлэх шаардлагатай байна.

3. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн эрсдэлийн үнэлгээ хийлгээгүй, осол дөхсөн тохиолдлыг судалж бүртгээгүй, тоног төхөөрөмжийн цахилгааны шитийн газардуулгын хэмжилтийг мэргэжлийн байгууллагаар хийлгүүлээгүй, тоног төхөөрөмж ашиглалтын аюулгүй ажиллагааны шаардлага хангасан гэрчилгээг аваагүй, хүхрийн хүчилтэй орчинд агааржуулалтын системгүй, үйлдвэрийн барилга байгууламж нь аюулгүйн шаардлага хангахгүй байгаагаас хүний эрүүл аюулгүй орчинд ажиллах нөхцөлийг хангахгүй ажлын байр байна.

4. Манай улсад 2019 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн байдлаар 990856 тээврийн хэрэгсэл, сэргээгдэх эрчим хүч, үүрэн телефоны оператор компаниудын үйл ажиллагаа, ашиглалтаас жилд 271 мянга орчим хаягдал аккумулятор үүсч, дахин боловсруулах үйлдвэрийн асуудлыг шийдэхгүйгээс зориулалтын бус газар хадгалагдаж, ахуйн болон үйлдвэрийн хогийн цэгт хаягдаж байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэх нөхцөл бүрдэхээр байгаа тул хаягдал боловсруулах үйлдвэр байгуулах бүсийг тогтоох, газрын асуудлыг шийдвэрлэх нь зүйтэй юм.

5. Аккумулятор дахин боловсруулах үйлдвэрийг байгуулахад сүүлийн үеийн техник технологийн шийдэл бүхий бүрэн автоматжуулсан, байгаль орчинд ээлтэй техник технологийг нэвтрүүлэх шаардлагатай байна.

6. Цацрагийн хяналт шинжилгээгээр үйлдвэрийн хашаа болон гадна орчин, үйлдвэрийн дамжлаг, нуурын усанд цацраг идэвхит бодис зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтрээгүй бөгөөд үйлдвэрийн үйл ажиллагаанаас байгаль орчинд цацрагийн бохирдол үүсээгүй байна.

**Ес. Цаашид авах арга хэмжээний санал:**

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР, БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ,  
ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ ЗУРАГ ЗҮЙН ГАЗАРТ**

1. Аюултай хог хаягдлын ланьфилийн байгууламж, аюултай хог хаягдал цуглуулах цэг, аюултай хог хаягдал дахин боловсруулах үйлдвэрийн газрын байршлыг

нэгдсэн цогц байхаар тогтоож өгөх, аюултай хог хаягдал дахин боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагаанд төрөөс дэмжлэг үзүүлэх;

2. Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлагын баримт бичигт тусгасан газарт аюултай хог хаягдал дахин боловсруулах үйлдвэрүүдийн судалгааг гаргаж, газрын хэмжээг үнэн зөв тогтоож, эрүүл ахуйн хамгаалалтын бүсийг стандартад тогтоосон хэмжээгээр улсын тусгай хэрэгцээнд авч, аюултай хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэрүүдийн газрын асуудлыг шийдвэрлэх.

3. Заламт гол ХХК, Эйч Би Жи Си ХХК /хуучнаар Болор Аграмба ХХК/-ийн болон аюултай хог хаягдал дахин боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагааг бүрмөсөн зогсоож, Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлагын баримт бичигт тусгасан газарт үйлдвэрийн үйл ажиллагааг нүүлгэн шилжүүлэх,

#### **БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМАНД**

4. Хуучин аккумулятор задалж, хүхрийн хүчил болон хар тугалгыг ялган хайлуулах үйлдвэрлэл явуулахад эрсдлээс урьдчилан сэргийлэх, сүүлийн үеийн техник технологийн шийдэл бүхий бүрэн автоматжуулсан, байгаль орчинд ээлтэй техник технологи бүхий үйлдвэрлэлийн үйл ажиллагааг дэмжих,

5. Байгаль орчинд ээлтэй техник технологийн үйл ажиллагаа инновацийг нэвтрүүлэх, үйл ажиллагааг зохицуулсан эрх зүйн орчинг бий болгох

#### **АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГАД**

6. Заламт гол" ХХК, Эйч Би Жи Си ХХК /хуучнаар "Болор Аграмба" ХХК/, "Хос даль" ХХК-ийн аккумулятор дахин боловсруулах үйлдвэрийн ойролцоох хүхрийн хүчил болон хүнд металлын бохирдлоор бохирдсон хөрсийг саармагжуулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх

БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЯНАЛТЫН УЛСЫН  
АХЛАХ БАЙЦААГЧ

У.ӨЛЗИЙЦЭЦЭГ

БАЙГАЛЬ ОРЧИН, ГАЗАР, ГЕОДЕЗИ  
ЗУРАГ ЗҮЙН ХЯНАЛТЫН УЛСЫН  
АХЛАХ БАЙЦААГЧ

Г.НАРАНТУЯА

БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЯНАЛТЫН УЛСЫН  
АХЛАХ БАЙЦААГЧ

С.НЯМЖАВ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ӨРГӨДЛИЙН БАЙНГЫН ХОРООНД


МОНГОЛ УЛСЫН МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН  
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧИЙН  
ДҮГНЭЛТ

Мэргэжлийн Хяналтын Ерөнхий Газар  
15170 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Барилгачдын талбай 13, Засгийн газрын XII байр  
Утас: 26-47-86, Факс: (976-51) 26-60-88  
E-mail: info@inspection.gov.mn  
http://www.inspection.gov.mn

2019.05.16 № 01-04-063/172

Үйл ажиллагааны тухай

Монгол Улсын Ерөнхий сайдаас өгсөн үүрэг даалгавар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын баталсан 01/196 тоот удирдамжийн дагуу Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын Байгаль орчны хэлтсийн дарга, улсын ахлах байцаагч Д.Цэрэндаш ахалж, Байгаль орчны хяналтын улсын ахлах байцаагч У.Өлзийцэцэг, С.Нямжав, Байгаль орчин, газар, геодези зураг зүйн хяналтын улсын ахлах байцаагч Г.Нарантуяа, Эрүүл мэнд, боловсрол, соёлын хяналтын газрын орчны эрүүл ахуйн хяналтын улсын ахлах байцаагч Б.Баясгалан, Хөдөлмөр, нийгмийн хамгаалал, тусгай хяналтын газрын хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын ахлах байцаагч З.Мөнхтуул, хөдөлмөрийн хяналтын улсын ахлах байцаагч С.Баяраа, Цөмийн болон цацрагийн аюулгүй байдлын хяналтын газрын цацрагийн хяналтын улсын байцаагч Б.Бямбацогт, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн удирдлагын газрын ахлах мэргэжилтэн Д.Тэмүүлэн /тохиролцсоноор/, мэргэжилтэн А.Оюун /тохиролцсоноор/, Цагдаагийн ерөнхий газрын Мөрдөн байцаах газрын байгаль орчны эсрэг гэмт хэрэг шалгах хэлтсийн ахлах мөрдөгч цагдаагийн хошууч Ш.Хуягбаатар /тохиролцсоноор/, Нийслэлийн хот байгуулалт, хөгжлийн газрын ахлах мэргэжилтэн А.Баттөмөр /тохиролцсоноор/, Баянзүрх дүүргийн Газар, зохион байгуулалтын албаны дарга Д.Бат-Ундрах /тохиролцсоноор/, Монголын байгаль орчны иргэний зөвлөл ТББ-ийн удирдах зөвлөлийн гишүүн Н.Эрдэнэсайхан /тохиролцсоноор/ нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг хамтран Баянзүрх дүүргийн 11 дүгээр хороонд байрлах аккумулятор дахин боловсруулах "Хос Даль" ХХК-ийн үйл ажиллагаанд "Байгаль орчныг хамгаалах тухай", "Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай", "Усны тухай", "Газрын тухай", Кадастрын зураглал ба газрын тухай, Хаягжилтын тухай, "Химийн хорт болон аюултай бодисын тухай", "Хог хаягдлын тухай", "Эрүүл ахуйн тухай" хууль, "Хөдөлмөрийн тухай", "Хөдөлмөрийн аюулгүй байдал", "Цөмийн энергийн тухай" болон тэдгээрт нийцүүлэн гаргасан норм дүрэм, стандартын хэрэгжилт, үйлдвэрийн үйл



09 0193

ажиллагаанаас хүрээлэн буй орчин бохирдуулсан эсэхийг тогтоохоор 2019 оны 04 дүгээр сарын 29-ний өдрөөс 2019 оны 05 дугаар сарын 10-ны өдрүүдэд хяналт шалгалтыг хийж гүйцэтгэлээ.

Хос даль ХХК нь байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээгүй, холбогдох зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулж байсан тул 1802000134 тоот зөрчлийн хэрэг үүсгэн торгуулийн арга хэмжээ авч 2018 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн прокурорын тогтоол, 04 дүгээр сарын 24-ний өдрийн 02-04-194/50 тоот улсын ахлах байцаагчийн актаар үйл ажиллагааг нь зогсоосон байна. Үйлдвэр орчмын хөрснөөс авсан дээжинд сульфатын агууламж зөвшөөрөгдөх хэмжээнээс 47,7-178 дахин их гарсан гарч хүхрийн хүчлээр орчныг бохирдуулсан нь тогтоогдсон байна. Мөн хаягдал аккумуляторыг задлах үйл ажиллагаанаас үүсч байгаа хүхрийн хүчлийг дахин боловсруулах үйлдвэр болон устгах арга хэмжээг авдаггүй учраас хүхрийн хүчлийг хөрсөнд асгасан, хууль бусаар хадгалсан, хөрс бохирдуулсан нь тогтоогдсон учраас эрүүгийн хэрэг үүсгүүлэхээр 2018 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн 02-01/2197 тоот албан бичгийг Нийслэлийн Цагдаагийн газарт хүргүүлсэн.

Хос Даль ХХК-ийн үйл ажиллагаанд Цагдаагийн Ерөнхий газрын Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг мөрдөн шалгах хэлтэст эрүүгийн хэрэг үүсэн шалгагдаж байна.

Баянзүрх дүүргийн 2012 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн А/390 дугаар захирамжаар иргэн Эрхбат овогтой Тунгалагт 20000 м<sup>2</sup> га газар 5 жилийн хугацаатай ногооны газрын зориулалтаар газар эзэмшүүлэхээр шийдвэрлэж, 2013 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн иргэн, хуулийн этгээдэд газар эзэмшүүлэх гэрээг байгуулан улсын бүртгэлийн 133028/0116 дугаарт бүртгэсэн, нийслэлийн газрын кадастрын мэдээллийн санд нэгж талбарын 18665292420355 дугаарт бүртгэгдсэн байна. Иргэн Э.Тунгалаг ногооны зориулалттай газрыг Хос даль ХХК-д зориулалтыг өөрчилөн эзэмшүүлэхээр гэрээ байгуулсан байна.

Дээрх нөхцөл байдлыг нэгтгэн **ДҮГНЭХ** нь:

1. Хаягдал аккумулятороос хүхрийн хүчил ялгах, хартугалга хайлуулах үйлдвэрийн 1000 метрт байх эрүүл ахуйн хамгаалалтын бүсийг тогтоогоогүй, Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлагын баримт бичигт тусгагдаагүй аюултай хог хаягдлын байршлийн шаардлага хангахгүй газарт үйл ажиллагаа явуулж байсан Хос даль ХХК-ийн үйлдвэрийг хүн ам суурьшиж байгаа бүсээс нүүлгэн шилжүүлэх шаардлагатай байна.

2. Төлөвлөгөөт бус хяналт шалгалтаар 2018 онд үйлдвэр орчмын хөрснөөс авсан дээжний сульфатын агууламжийг Байгаль хамгаалал. Хөрс. хот суурин газрын хөрсний эрүүл ахуйн аюулгүй үзүүлэлт, бохирдлыг үнэлэх" MNS3297:2019 стандарттай

харьцуулахад зөвшөөрөгдөх хэмжээнээс 47,7-178 дахин их гарсан гарч байгаа нь үйлдвэрийн үйл ажиллагаанаас хүрээлэн буй орчинд хүхрийн хүчлийн бохирдол үүсч тухайн бүс нутагт амьдарч байгаа иргэд болон ажилчдын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх нөхцөл бүрдсэн байна.

3. Манай улсад 2019 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн байдлаар 990856 тээврийн хэрэгсэл, сэргээгдэх эрчим хүч, үүрэн телефоны оператор компаниудын үйл ажиллагаа, ашиглалтаас жилд 271 мянга орчим хаягдал аккумулятор үүсч, дахин боловсруулах үйлдвэрийн асуудлыг шийдэхгүйгээс зориулалтын бус газар хадгалагдаж, ахуйн болон үйлдвэрийн хогийн цэгт хаягдаж байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэх нөхцөл бүрдэхээр байгаа тул хаягдал боловсруулах үйлдвэр байгуулах бүсийг тогтоох, газрын асуудлыг шийдвэрлэх нь зүйтэй юм.

4. Аккумулятор дахин боловсруулах үйлдвэрийг байгуулахад сүүлийн үеийн техник технологийн шийдэл бүхий бүрэн автоматжуулсан, байгаль орчинд ээлтэй техник технологийг нэвтрүүлэх шаардлагатай байна.


5. Иргэн Э.Тунгалаг ногооны газрын зориулалтыг өөрчилсөн, Хос даль ХХК-д зориулалт бусаар эзэмшүүлэх эрх шилжүүлсэн нь Газрын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.3.1 дэх заалтыг зөрчсөн байна.

Улсын байцаагчийн гаргасан шийдвэрийг эс зөвшөөрвөл Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэгт заасны дагуу хяналт шалгалт хийсэн байгууллагын удирдлагад гомдол гаргах эрхтэй.

#### ДУГНЭЛТ ГАРГАСАН:



БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЯНАЛТЫН  
ХЭЛТСИЙН ДАРГА, УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ  Д.ЦЭРЭНДАШ

БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЯНАЛТЫН УЛСЫН  
АХЛАХ БАЙЦААГЧ  У.ӨЛЗИЙЦЭЦЭГ

БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЯНАЛТЫН УЛСЫН  
АХЛАХ БАЙЦААГЧ  С.НЯМЖАВ

БАЙГАЛЬ ОРЧИН, ГАЗАР, ГЕОДЕЗИ  
ЗУРАГ ЗҮЙН ХЯНАЛТЫН УЛСЫН  
АХЛАХ БАЙЦААГЧ  Г.НАРАНТУЯА

ХӨДӨЛМӨРИЙН ЭРҮҮЛ АХУЙН ХЯНАЛТЫН  
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ  З.МӨНХТУУЛ





МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ӨРГӨДЛИЙН БАЙНГЫН ХОРООНД


МОНГОЛ УЛСЫН МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН  
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧИЙН  
ДҮГНЭЛТ

Мэргэжлийн Хяналтын Ерөнхий Газар  
15170 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Барилгачдын талбай 13, Засгийн газрын XII байр  
Утас: 26-47-86, Факс: (976-51) 26-60-88  
E-mail: info@inspection.gov.mn  
http://www.inspection.gov.mn

2019.05.16 № 01-04-063/171

Үйл ажиллагааны тухай

Монгол Улсын Ерөнхий сайдаас өгсөн үүрэг даалгавар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын баталсан 01/196 тоот удирдамжийн дагуу Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын Байгаль орчны хэлтсийн дарга, улсын ахлах байцаагч Д.Цэрэндаш ахалж, Байгаль орчны хяналтын улсын ахлах байцаагч У.Өлзийцэцэг, С.Нямжав, Байгаль орчин, газар, геодези зураг зүйн хяналтын улсын ахлах байцаагч Г.Нарантуяа, Эрүүл мэнд, боловсрол, соёлын хяналтын газрын орчны эрүүл ахуйн хяналтын улсын ахлах байцаагч Б.Баясгалан, Хөдөлмөр, нийгмийн хамгаалал, тусгай хяналтын газрын хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын ахлах байцаагч З.Мөнхтуул, хөдөлмөрийн хяналтын улсын ахлах байцаагч С.Баяраа, Цөмийн болон цацрагийн аюулгүй байдлын хяналтын газрын цацрагийн хяналтын улсын байцаагч Б.Бямбацогт, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн удирдлагын газрын ахлах мэргэжилтэн Д.Тэмүүлэн /тохиролцсоноор/, мэргэжилтэн А.Оюун /тохиролцсоноор/, Цагдаагийн ерөнхий газрын Мөрдөн байцаах газрын байгаль орчны эсрэг гэмт хэрэг шалгах хэлтсийн ахлах мөрдөгч цагдаагийн хошууч Ш.Хуягбаатар /тохиролцсоноор/, Нийслэлийн хот байгуулалт, хөгжлийн газрын ахлах мэргэжилтэн А.Баттөмөр /тохиролцсоноор/, Баянзүрх дүүргийн Газар, зохион байгуулалтын албаны дарга Д.Бат-Ундрах /тохиролцсоноор/, Монголын байгаль орчны иргэний зөвлөл ТББ-ийн удирдах зөвлөлийн гишүүн Н.Эрдэнэсайхан /тохиролцсоноор/ нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг хамтран Налайх дүүргийн 4 дүгээр хороонд байрлах Эйч Би Жи Си” ХХК /хуучнаар “Болор Аграмба” ХХК/-ийн үйл ажиллагаанд “Байгаль орчныг хамгаалах тухай”, “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай”, “Усны тухай”, “Газрын тухай”, Кадастрын зураглал ба газрын тухай, Хаягжилтын тухай, “Химийн хорт болон аюултай бодисын тухай”, “Хог хаягдлын тухай”, “Эрүүл ахуйн тухай” хууль, “Хөдөлмөрийн тухай”, “Хөдөлмөрийн аюулгүй байдал”, “Цөмийн энергийн тухай”



09 0179

болон тэдгээрт нийцүүлэн гаргасан норм дүрэм, стандартын хэрэгжилт, үйлдвэрийн үйл ажиллагаанаас хүрээлэн буй орчин бохирдуулсан эсэхийг тогтоохоор 2019 оны 04 дүгээр сарын 29-ний өдрөөс 2019 оны 05 дугаар сарын 10-ны өдрүүдэд хяналт шалгалтыг хийж гүйцэтгэлээ.

Болор Аграмба ХХК нь байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээгүй, холбогдох зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулж байсан зөрчилд улсын байцаагчийн 02-04-334/258 тоот акт үйлдэж үйл ажиллагааг 2018 онд зогсоосон байна. Болор Аграмба ХХК үйлдвэрийн тоног төхөөрөмж, газрыг Эйч Би Жи Си ХХК-д худалдан борлуулсан бөгөөд тухайн компани өөрийн нэр дээр шилжүүлэн авсан байна.

Налайх дүүргийн Засаг даргын 2012 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн 463 дугаар захирамжаар Болор аграмба ХХК-д 17943 м<sup>2</sup> тус дүүргийн 4 дүгээр хорооны нутаг дэвсгэрт үйлдвэрийн бүсэд үйлдвэрлэлийн зориулалтаар 15 жилийн хугацаатай газар эзэмшүүлэхээр шийдвэрлэж, аж ахуйн нэгж байгууллагын 0294016 дугаар гэрчилгээг олгож, нийслэлийн газрын кадастрын мэдээллийн санд нэгж талбарын 18673295076727 дугаарт бүртгэгдсэн байна.

Налайх дүүргийн Засаг даргын 2019 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн А/27 дугаар захирамжаар Болор Аграмба ХХК-д 10405.0 га газрыг 15 жилийн хугацаатай үйлдвэрийн барилга, байгууламж, бусад газар зориулалтаар эзэмшүүлэхээр шийдвэрлэж аж ахуйн нэгж, байгууллагын газар эзэмших эрхийн 000001800 дугаар гэрчилгээг олгож, газрын кадастрын мэдээллийн санд 1260510018 дугаарт бүртгэгдсэн байна.

Налайх дүүргийн Засаг даргын 2019 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн А/27 дугаар захирамжаар Эйч Би Жи Си ХХК-д үйлдвэрлэлийн зориулалтаар 15 жилийн хугацаатай газар эзэмших эрхийн гэрчилгээг шилжүүлэн шийдвэрлэж, аж ахуйн нэгж, байгууллагын газар эзэмших эрхийн 000001706 дугаар гэрчилгээ олгосон байна. Нийслэлийн Газрын кадастрын мэдээллийн санд 1260510017 дугаарт бүртгэгдсэн байна. Эйч Би Жи Си ХХК нь Болор аграмба ХХК-аас худалдан авсан 2 үл хөдлөх барилгад ямар нэг үйл ажиллагаа явуулаагүй, шинээр эзэмшиж байгаа газарт барилгын ажил эхлүүлэхээр төлөвлөж байсан байна.

Эйч Би Жи Си ХХК /хуучнаар "Болор Аграмба" ХХК/-ийн аккумулятор дахин боловсруулах үйлдвэрийн ойролцоох орчны хөрснөөс 4 дээж авч, химийн шинжилгээнд хар тугалга, хром, зэс, цайр, хүнцэл, кадмийн үзүүлэлтээр итгэмжлэгдсэн "SGS IMME Mongolia" ХХК-ийн лаборатори, сульфатын үзүүлэлтээр Байгаль орчин, аялал жуулчлалын яамны харъяа Байгаль орчны төв лабораторит шинжилгээнд тус тус хүргүүлж ажилласан.

Дээрх нөхцөл байдлыг нэгтгэн **ДҮГНЭХ** нь:



1. Эйч Би Жи Си ХХК /хуучнаар Болор Аграмба ХХК/-ийн аккумулятор дахин боловсруулах үйлдвэрийн ойролцоох орчны хөрсний хүнд металлын химийн шинжилгээний дүнг “Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ” MNS5850:2008 стандартад харьцуулахад зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хар тугалгын агууламж 19,4-100 дахин их, хүнцэлийн агууламж 3-6.3 дахин их, кадмийн агууламж 13 дахин их, “Байгаль хамгаалал. Хөрс. хот суурин газрын хөрсний эрүүл ахуйн аюулгүй үзүүлэлт, бохирдлыг үнэлэх” MNS3297:2019 стандарттай сульфатын агууламжийг харьцуулахад зөвшөөрөгдөх 138-466 дахин их гарсан нь үйлдвэрийн үйл ажиллагаанаас хүрээлэн буй орчинд хүхрийн хүчил болон хүнд металлын бохирдол үүсч тухайн бүс нутагт амьдарч байгаа иргэдийн эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх нөхцөл бүрдсэн байна.


2. Налайх дүүргийн Засаг даргын 2019 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн А/27 дугаар захирамжаар Болор аграмба ХХК-иас Эйч Би Жи Си ХХК-д 10405.0 га газрыг 15 жилийн хугацаатай үйлдвэрийн барилга, байгууламж, бусад газар зориулалтаар эзэмшүүлэхээр шилжүүлэн захирамжилсан нь Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлагын баримт бичгийн 4.4 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1 дэх заалтыг зөрчиж байна.

3. Хаягдал аккумулятороос хүхрийн хүчил ялгах, хартугалга хайлуулах үйлдвэрийн 1000 метрт байх эрүүл ахуйн хамгаалалтын бүсийг тогтоогоогүй, Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлагын баримт бичигт тусгагдаагүй аюултай хог хаягдлын байршлийн шаардлага хангахгүй газарт үйл ажиллагаа явуулж байгаа “Эйч Би Жи Си” ХХК /хуучнаар “Болор Аграмба” ХХК/-ийн үйлдвэрийг хүн ам суурьшиж байгаа бүсээс нүүлгэн шилжүүлэх шаардлагатай.

4. Манай улсад 2019 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн байдлаар 990856 тээврийн хэрэгсэл, сэргээгдэх эрчим хүч, үүрэн телефоны оператор компаниудын үйл ажиллагаа, ашиглалтаас жилд 271 мянга орчим хаягдал аккумулятор үүсч, дахин боловсруулах үйлдвэрийн асуудлыг шийдэхгүйгээс зориулалтын бус газар хадгалагдаж, ахуйн болон үйлдвэрийн хогийн цэгт хаягдаж байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэх нөхцөл бүрдэхээр байгаа тул хаягдал боловсруулах үйлдвэр байгуулах бүсийг тогтоох, газрын асуудлыг шийдвэрлэх нь зүйтэй юм.

5. Аккумулятор дахин боловсруулах үйлдвэрийг байгуулахад сүүлийн үеийн техник технологийн шийдэл бүхий бүрэн автоматжуулсан, байгаль орчинд ээлтэй техник технологийг нэвтрүүлэх шаардлагатай байна.

Улсын байцаагчийн гаргасан шийдвэрийг эс зөвшөөрвөл Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэгт заасны дагуу хяналт шалгалт хийсэн байгууллагын удирдлагад гомдол гаргах эрхтэй.



ДУГНЭЛТ ГАРГАСАН:

БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЯНАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА, УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ Д.ЦЭРЭНДАШ

БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЯНАЛТЫН УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ У.ӨЛЗИЙЦЭЦЭГ

БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЯНАЛТЫН УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ С.НЯМЖАВ

БАЙГАЛЬ ОРЧИН, ГАЗАР, ГЕОДЕЗИ ЗУРАГ ЗҮЙН ХЯНАЛТЫН УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ Г.НАРАНТУЯА

ОРЧНЫ ЭРҮҮЛ АХУЙН ХЯНАЛТЫН УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ Б.БАЯСГАЛАН

ХӨДӨЛМӨРИЙН ЭРҮҮЛ АХУЙН ХЯНАЛТЫН УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ З.МӨНХТУУЛ





МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ӨРГӨДЛИЙН БАЙНГЫН ХОРООНД


МОНГОЛ УЛСЫН МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН  
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧИЙН  
ДҮГНЭЛТ

Мэргэжлийн Хяналтын Ерөнхий Газар  
15170 Улаанбаатар хот, Чингалтэй дүүрэг,  
Барилгачдын талбай 13, Засгийн газрын XII байр  
Утас: 26-47-86, Факс: (976-51) 26-60-88  
E-mail: info@inspection.gov.mn  
http://www.inspection.gov.mn

2019.05.16 № 01-04-063/170

Үйл ажиллагааны тухай

Монгол Улсын Ерөнхий сайдаас өгсөн үүрэг даалгавар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын баталсан 01/196 тоот удирдамжийн дагуу Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын Байгаль орчны хэлтсийн дарга, улсын ахлах байцаагч Д.Цэрэндаш ахалж, Байгаль орчны хяналтын улсын ахлах байцаагч У.Өлзийцэцэг, С.Нямжав, Байгаль орчин, газар, геодези зураг зүйн хяналтын улсын ахлах байцаагч Г.Нарантуяа, Эрүүл мэнд, боловсрол, соёлын хяналтын газрын орчны эрүүл ахуйн хяналтын улсын ахлах байцаагч Б.Баясгалан, Хөдөлмөр, нийгмийн хамгаалал, тусгай хяналтын газрын хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын ахлах байцаагч З.Мөнхтуул, хөдөлмөрийн хяналтын улсын ахлах байцаагч С.Баяраа, Цөмийн болон цацрагийн аюулгүй байдлын хяналтын газрын цацрагийн хяналтын улсын байцаагч Б.Бямбацогт, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн удирдлагын газрын ахлах мэргэжилтэн Д.Тэмүүлин /тохиролцсоноор/, мэргэжилтэн А.Оюун /тохиролцсоноор/, Цагдаагийн ерөнхий газрын Мөрдөн байцаах газрын байгаль орчны эсрэг гэмт хэрэг шалгах хэлтсийн ахлах мөрдөгч цагдаагийн хошууч Ш.Хуягбаатар /тохиролцсоноор/, Нийслэлийн хот байгуулалт, хөгжлийн газрын ахлах мэргэжилтэн А.Баттөмөр /тохиролцсоноор/, Баянзүрх дүүргийн Газар, зохион байгуулалтын албаны дарга Д.Бат-Ундрах /тохиролцсоноор/, Монголын байгаль орчны иргэний зөвлөл ТББ-ийн удирдах зөвлөлийн гишүүн Н.Эрдэнэсайхан /тохиролцсоноор/ нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг хамтран Баянзүрх дүүргийн 11 дүгээр хороонд байрлах аккумулятор дахин боловсруулах "Заламт гол" ХХК-ийн үйл ажиллагаанд "Байгаль орчныг хамгаалах тухай", "Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай", "Усны тухай", "Газрын тухай", Кадастрын зураглал ба газрын тухай, Хаягжилтын тухай, "Химийн хорт болон аюултай бодисын тухай", "Хог хаягдлын тухай", "Эрүүл ахуйн тухай" хууль, "Хөдөлмөрийн тухай", "Хөдөлмөрийн аюулгүй байдал", "Цөмийн энергийн тухай" болон тэдгээрт нийцүүлэн гаргасан норм дүрэм, стандартын хэрэгжилт, үйлдвэрийн үйл ажиллагаанаас хүрээлэн буй орчин бохирдуулсан эсэхийг тогтоохоор 2019 оны 04



09 0192

дүгээр сарын 29-ний өдрөөс 2019 оны 05 дугаар сарын 10-ны өдрүүдэд хяналт шалгалтыг хийж гүйцэтгэлээ.

Заламт гол ХХК нь хаягдал түүхий эд болох ашигласан аккумулятораас хар тугалга, хүхрийн хүчлийг ялган, хар тугалга хайлах үйлдвэрийг 2013 онд ашиглалтад оруулсан байна. Үйлдвэрийн байр нь төмөр карказ бүхий сэндвичин барилга, агааржуулалтын системгүй, хаягдал түүхий эд хүлээн авах, хүчил ялган юүлэх, хар тугалга бүхий ялтасыг ялгах, хар тугалга хайлах, хэвэнд цутгах хэсэг, нүүрс бутлах, нүүрс оруулах тоног төхөөрөмжийг байрлуулсан нийт 720м<sup>2</sup> талбайтай байна. Хаягдал түүхий эд боловсруулах үйлдвэр нь аккумуляторыг гар аргаар задладаг хоцрогдсон техник технологитой, тугалга хайлах хэсгийг тусгаарлаагүй, хүхрийн хүчлийг ялган авах үйл ажиллагааг механикжуулаагүй, ажлын байранд ил задгай сувгаар дамжуулан хуримтлуулдаг, ажлын байрны агаарт хартугалгын болон хүхрийн хүчлийн ууршилт ихтэй байна.

Тугалга хайлуулах зуух нь нүүрсээр ажиллах ба 1200-1300 орчим хэмийн халуунд тугалгыг хайлж, цэвэршүүлээд хэвэнд цутгаж, 45 кг хар тугалган гулдмай үйлдвэрлэдэг байна. Жилд 75600 ширхэг, хоногт 360 ширхэг гулдмай үйлдвэрлэх хүчин чадалтай. Аккумуляторыг дахин боловсруулах үйл ажиллагаанаас 28-35%-ийн хүхрийн хүчлийн уусмалыг ялган авч Орхон аймагт үйл ажиллагаа явуулдаг Эрдмин ХХК-д Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас химийн бодис худалдах №0001116 дугаартай зөвшөөрлийн үндсэн дээр 610 тонныг нийлүүлсэн байна. Аккумуляторын гадна талын хүхрийн хүчлээр бохирдсон хуванцарыг зориулалтын бус агуулахад хадгалж байна.

2018 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг Нийслэлийн байгаль орчны газрын даргын 2016 оны А/95 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан ажлын хэсэг хүлээж авч, 85.5%тай дүгнэгдсэн ба 2019 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг Байгаль орчин, аялал жуулчлалын яамаар батлуулсан байна.

Ус ашиглах гэрээг Баянзүрх дүүргийн Дэд бүтэц, хот төлөвлөлт хариуцсан төслийн удирдагч засаг даргын орлогч Т.Батцогттой 2018.11.17-2019.11.17-ны өдрийг хүртэл хийж байгуулсан бөгөөд 07 дугаартай ус ашиглах эрхийн бичиг авсан байна. Мөн гүний усны худагт METRON загварын 3,5 м<sup>3</sup> хэмжих хязгаартай 0801486 дугаартай усны тоолуур тавиулж Стандартчилал, хэмжил зүйн газрын 024 лацаар битүүмжилж, баталгаажуулсан байна. Усны төлбөрийг гэрээний дагуу төлж барагдуулсан байна.

Баянзүрх дүүргийн Засаг даргын 2018 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн А/467 дугаар захирамжаар иргэн И.Батчимэгийн эзэмшиж байгаа газрын эрхийн гэрчилгээг Заламт гол ХХК-д шилжүүлэн захирамжилсан байна. Дүүргийн Газрын албанаас аж ахуйн нэгж, байгууллагын газар эзэмших эрхийн 000001803 гэрчилгээг 2019 оны 02

дугаар сарын 20-ны өдөр олгож, газар эзэмших гэрээг 2018 оны 05 сарын 08-ны өдөр байгуулсан байна.

Заламт гол ХХК-ийн аккумулятор дахин боловсруулах үйлдвэрийн ойролцоох 10 цэгээс цацрагийн хэмжилт, орчны хөрснөөс 4 дээж авч, химийн шинжилгээнд хар тугалга, хром, зэс, цайр, хүнцэл, кадмийн үзүүлэлтээр итгэмжлэгдсэн SGS IMME Mongolia ХХК-ийн лаборатори, сульфатын үзүүлэлтээр Байгаль орчин, аялал жуулчлалын яамны харъяа Байгаль орчны төв лабораторит шинжилгээнд тус тус хүргүүлж ажилласан.

Дээрх нөхцөл байдлыг нэгтгэн **ДҮГНЭХ** нь:

1. Заламт гол ХХК-ийн аккумулятор дахин боловсруулах үйлдвэрүүдийн ойролцоох орчны хөрсний хүнд металлын химийн шинжилгээний дүнг "Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ" MNS5850:2008 стандарттай харьцуулахад зөвшөөрөгдөх хэмжээнээс хар тугалгын агууламж 4.5-100 дахин их, хүнцэлийн агууламж 3.8-7.2 дахин их, кадмийн агууламж 0.6-3.3 дахин их, "Байгаль хамгаалал. Хөрс. хот суурин газрын хөрсний эрүүл ахуйн аюулгүй үзүүлэлт, бохирдлыг үнэлэх" MNS3297:2019 стандарттай сульфатын агууламжийг харьцуулахад зөвшөөрөгдөх хэмжээнээс 0.3-81.8 дахин их гарсан гарч байгаа нь үйлдвэрийн үйл ажиллагаанаас хүрээлэн буй орчинд хүхрийн хүчил болон хүнд металлын бохирдол үүсч тухайн бүс нутагт амьдарч байгаа иргэд болон ажилчдын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх нөхцөл бүрдсэн байна.

2. Цацрагийн хяналт шинжилгээгээр үйлдвэрийн хашаа болон гадна орчин, үйлдвэрийн дамжлаг, нуурын усанд гамма цацрагийн тунгийн чадал 0.07-0.18 мкЗв/цаг, гадаргуудын бохирдол 8-15 бөөм/минут\*см<sup>2</sup> байгаа нь цацраг идэвхит бодис зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтрээгүй бөгөөд үйлдвэрийн үйл ажиллагаанаас байгаль орчинд цацрагийн бохирдол үүсээгүй байна.

3. Хаягдал аккумулятороос хүхрийн хүчил ялгах, хартугалга хайлуулах үйлдвэрийн 1000 метрт байх эрүүл ахуйн хамгаалалтын бүсийг тогтоогоогүй, Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлагын баримт бичигт тусгагдаагүй аюултай хог хаягдлын байршлийн шаардлага хангахгүй газарт үйл ажиллагаа явуулж байгаа Заламт гол ХХК-ийн үйлдвэрийг хүн ам суурьшиж байгаа бүсээс нүүлгэн шилжүүлэх шаардлагатай байна.

4. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн эрсдэлийн үнэлгээ хийлгээгүй, осол дөхсөн тохиолдлыг судалж бүртгээгүй, тоног төхөөрөмжийн цахилгааны шитийн газардуулгын хэмжилтийг мэргэжлийн байгууллагаар хийлгүүлээгүй, тоног төхөөрөмж ашиглалтын аюулгүй ажиллагааны шаардлага хангасан гэрчилгээг аваагүй, хүхрийн хүчилтэй орчинд агааржуулалтын системгүй, үйлдвэрийн барилга байгууламж нь

аюулгүйн шаардлага хангахгүй байгаагаас хүний эрүүл аюулгүй орчинд ажиллах нөхцөл хангагдаагүй нь Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль 9 дүгээр зүйлийн 9.1.3, 28 дугаар зүйлийн 28.1.1, 28.1.4 дэх заалтуудыг зөрчиж байна.

5. Заламт гол ХХК нь аюултай хог хаягдал болох аккумуляторыг дахин боловсруулахдаа эрх бүхий байгууллагаас тусгай зөвшөөрөл аваагүй, үйл ажиллагаанаас үүсч буй хүхрийн хүчлийн бохирдолтой хуванцар хаягдлыг эрх бүхий байгууллагад өгч устгах арга хэмжээг аваагүй, хаягдал түүхий эд боловсруулах үйлдвэрийн технологи нь хоцрогдсон, тугалга хайлах хэсгийг тусгаарлаагүй, хүхрийн хүчлийг ялган авах үйл ажиллагааг механикжуулаагүй, ажлын байранд хүхрийн хүчлийг ил задгай сувгаар дамжуулан хуримтлуулдаг, ажлын байрны агаарт хар тугалгын болон хүхрийн хүчлийн ууршилт их байгаа нь Химийн хорт болон аюултай бодисын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх заалт, Хог хаягдлын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1, 37 дугаар зүйлийн 37.1 дэх заалтуудыг зөрчиж байна.

6. Баянзүрх дүүргийн Засаг даргын 2018 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн А/467 захирамжаар иргэн И.Батчимэгээс Заламт гол ХХК-д 7800м<sup>2</sup> газрыг эзэмшүүлэхээр шилжүүлэн захирамжилсан нь Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлагын баримт бичгийн 4.4 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1 дэх заалтыг зөрчиж байна.

7. Манай улсад 2019 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн байдлаар 990856 тээврийн хэрэгсэл, сэргээгдэх эрчим хүч, үүрэн телефоны оператор компаниудын үйл ажиллагаа, ашиглалтаас жилд 271 мянга орчим хаягдал аккумулятор үүсч, дахин боловсруулах үйлдвэрийн асуудлыг шийдэхгүйгээс зориулалтын бус газар хадгалагдаж, ахуйн болон үйлдвэрийн хогийн цэгт хаягдаж байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэх нөхцөл бүрдэхээр байгаа тул хаягдал боловсруулах үйлдвэр байгуулах бүсийг тогтоох, газрын асуудлыг шийдвэрлэх нь зүйтэй юм.

8. Аккумулятор дахин боловсруулах үйлдвэрийг байгуулахад сүүлийн үеийн техник технологийн шийдэл бүхий бүрэн автоматжуулсан, байгаль орчинд ээлтэй техник технологийг нэвтрүүлэх шаардлагатай байна.

Улсын /ахлах/ байцаагчийн гаргасан шийдвэрийг эс зөвшөөрвөл Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэгт заасны дагуу хяналт шалгалт хийсэн байгууллагын удирдлагад гомдол гаргах эрхтэй.

ДҮГНЭЛТ ГАРГАСАН:

БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЯНАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА,  
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ



Д.ЦЭРЭНДАШ

БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЯНАЛТЫН УЛСЫН  
АХЛАХ БАЙЦААГЧ

БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЯНАЛТЫН УЛСЫН  
АХЛАХ БАЙЦААГЧ

БАЙГАЛЬ ОРЧИН, ГАЗАР, ГЕОДЕЗИ  
ЗУРАГ ЗҮЙН ХЯНАЛТЫН УЛСЫН  
АХЛАХ БАЙЦААГЧ

ОРЧНЫ ЭРҮҮЛ АХУЙН ХЯНАЛТЫН  
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ

ХӨДӨЛМӨРИЙН ЭРҮҮЛ АХУЙН ХЯНАЛТЫН  
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ

ЦАЦРАГИЙН ХЯНАЛТЫН УЛСЫН  
БАЙЦААГЧ

У.ӨЛЗИЙЦЭЦЭГ

С.НЯМЖАВ

Г.НАРАНТУЯА

ХТ04466

Б.БАЯСГАЛАН

З.МӨНХТУУЛ

Б.БЯМБАЦОГТ